МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХҮЙСИЙН ТЭГШ ЭРХ ТӨВ

KOREA

MINISTRY OF GENDER EQUALITY AND FAMILY

The Asia Foundation

# БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ОХИД , ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ



# БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

## Хүн худалдаалах гэмт хэрэг гэж юу вэ?



Хэн нэгнийг эд бараа мэт нэг нэгэндээ худалдаж, мөлжих, ашиглах үйлдлийг **Хүн худалдаалах гэмт хэрэг** гэж үздэг.

Гэмт этгээдүүд өөрсдийн жинхэнэ зорилгоо нуун далдалж, өндөр цалинтай ажилд оруулж өгнө хэмээн худал амлаж тэднийг өөртөө элсүүлэх, улмаар хохирогчдыг хил нэвтрүүлэн эсвэл дотоодод мөлжлөгт өртүүлэх нөхцөл байдалд хүргэх, хохирогчид хийх ажлынхаа талаар ерөнхийд нь мэдэж байгаа боловч бодит байдлын талаар ямар нэг мэдээлэл аваагүй зэрэг тохиолдлуудыг бүгдийг нь Хүн худалдаалах гэмт хэрэгт хамааруулан тооцдог.

Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.

*Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл.*



## Хүн худалдаалах гэмт хэрэг нь дараах байдлаар үйлдэгддэг.



### Үйлдэл

- Элсүүлэх,
- Тээвэрлэх,
- Орогнуулах,
- Дамжуулах,
- Хүлээн авах



### Арга

- Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх
- Хууран мэхлэх
- Хулгайлах
- Итгэл эвдэх
- Эрх мэдлээ урвуулан ашиглах
- Эмзэг байдлыг нь далимдуулах
- Бусдыг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг хүнд төлбөр төлж, хахуульдах



### Зорилго

- Биеийг нь үнэлүүлэх,
- Бэлгийн мөлжлөгт оруулах,
- Албадан хөдөлмөрлүүлэх,
- Боолчлох буюу түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах,
- Эд эрхтнийг нь авах

*Таньдаг хүн маань намайг гадагшаа хамт явж, буудалд үйлчлэгчийн ажил хийе, энд ажил хийж байснаас боломжийн цалинтай гэж ятгасан. Надад гадагшаа явах мөнгө байхгүй гэсэн чинь зардлыг маань дааж авч явна. Очоод ажлаа хийгээд төлөөрэй гэсэн болохоор би түүнд итгэж явахаар шийдсэн. Тухайн газар очсоны дараа найз маань намайг нэг зочид буудалд аваачиж, биеэ үнэлж мөнгө олох хэрэгтэй гэж хэлсэн. Би энэ ажлыг хийхгүй гэж эсэргүүцэхэд тэд намайг дарамталж, заналхийлэн биеэ үнэлэхээс аргагүй нөхцөл байдалд оруулсан. Миний бичиг баримтыг минь хураан авч, өрөө төл гэж шаардсан. Намайг тухайн газраас гаргахгүй байсан учир би хаана ирснээ сайн мэдэхгүй байсан....*

*Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийн түүхээс......*

## Бэлгийн мөлжлөг гэж юу вэ?



Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг авах үйлдлийг ойлгоно. Энэ гэмт хэрэг нь бусдаас зөвшөөрөл авалгүйгээр үйлдэгддэгээрээ онцлогтой.

Бэлгийн мөлжлөг бол хүн худалдаалах гэмт хэргийн нэг төрөл юм. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж: эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг нь хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харилцаанд албадан оруулахыг хэлнэ.

- *Би энд зөөгчөөр ажиллахаар ирсэн. Гэвч тэд хүчээр миний биеийг үнэлүүлэх гэсэн...*
- *Намайг зочид буудалд үйлчлэгчийн ажилд оруулна гэсэн ч намайг дарамталж, эрхшээлдээ оруулан биеэ үнэлэх ажил хий гэсэн....*

## ХТЭТ–ийн үйлчлүүлэгчдийн мэдээлэл (2003–2019)




Хохирогчдын 71.5 хувь нь бэлгийн мөлжлөгт өртсөн байна.




Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдын 90,5 хувь нь охид, эмэгтэйчүүд байсан байна.

## Хохирогч гэж хэн бэ?



Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ. (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйл)

## Хэн хохирогч болох эрсдэлтэй вэ?



Эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд хэн ч энэ гэмт хэргийн хохирогч болж болно. Гэмт хэрэгтнүүд нь хохирогчдод хийх ажлын талаар хангалтгүй мэдээлэл өгч, улмаар тэднийг зөвшөөрөхөөс өөр аргагүй нөхцөл байдалд оруулдаг.

## Бэлгийн мөлжлөгийн хохирогч болсноо хэрхэн мэдэх вэ?

Хохирогч болсон эсэхээ дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу бөглөөд үзээрэй.

| | Асуултууд | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Хэн нэгэн танд гадаадад болон дотоодод өндөр цалинтай ажил хийх санал тавьсан уу? | | |
| 2 | Хэн нэгэн таны гадаад улс руу зорчихтой холбоотой зардлыг төлж байгаа юу? | | |
| 3 | Бичиг баримт, гадаад паспортаа өөртөө хадгалж байгаа юу? | | |
| 4 | Хэн нэгэн танд хүч хэрэглэж эсвэл албадан биеийг нь үнэлүүлж байгаа юу? | | |
| 5 | Хэн нэгэн танд хүчээр, албадан хар тамхи, мансууруулах бодис хэрэглүүлсэн үү? | | |
| 6 | Танд анх амласан цалингаа өгч байгаа юу? | | |
| 7 | Таныг өрийн барьцаанд оруулан хүчээр биеийг нь үнэлүүлж байгаа юу? | | |
| 8 | Таны чөлөөтэй зорчих, гарах орох эрхийг хязгаарласан уу? | | |
| 9 | Хэрвээ та 18-аас доош настай бөгөөд хэн нэгэн таны биеийг үнэлүүлж, ашиг орлого олж байгаа юу? | | |

Та 3-аас дээш асуултад **"Тийм"** гэж хариулсан бол бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон байх эрсдэлтэй байна.

## Бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон тохиолдолд яаралтай авах арга хэмжээ:

- Цагдаагийн байгууллагын **112** утас,
- Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар яаралтай мэдээлэл, зөвлөгөө өгдөг **1800–1903** утсанд хандаарай.
- Хэрвээ та гадаадад байгаа бол өөрийн улсын Элчин Сайдын Яам, Консулын газарт хандах боломжтой. Аялал хийхээсээ өмнө өөрийнхөө очих гэж байгаа улсад байгаа Монгол Улсын Элчин Сайдын Яамны утас, хаягийг мэдэж аваарай.
- Гэр бүлийнхэнтэйгээ болон танд тусламж үзүүлж болох хэн нэгэнтэй холбогдож, хаана ямар нөхцөлд байгаа талаараа хэлж, тусламж хүсээрэй.

Хэрвээ та хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар **1800–1903** утсанд холбогдвол шуурхай мэдээлэл, зөвлөгөөг авахаас гадна **“Хүйсийн тэгш эрхийн төв“** ТББ-ын хохирогч хамгааллын чиглэлээр үзүүлж буй дараах үйлчилгээнд хамрагдах боломжтой.





Тус байгууллага нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээ, туслалцаа үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.



## Бид танд дараах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

| СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ | ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ |
|---|---|
| - Хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх<br>- Сэтгэлзүйн тест хийх, зөвлөгөө өгөх<br>- Удаан хугацааны сэтгэл заслын үйлчилгээ хэрэгтэй тохиолдолд энэ чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдтэй холбож өгөх | - Хуулийн байгууллагад хохирогчийг өргөдөл гаргахад нь туслах<br>- Холбогдох асуудлаар хууль зүйн анхан шатны мэдээлэл, зөвлөгөө өгөх<br>- Хохирогчийг энэ асуудлаар мэргэшсэн өмгөөлөгчтэй холбож өгөх, үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх<br>- Шүүх хуралд хохирогчийн сэтгэлзүйг бэлтгэх, мэдээлэл зөвлөгөө өгөх |
| **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ** | **ХАМГААЛАХ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ** |
| - Эрүүл мэндийн байгууллагатай холбож өгөх<br>- Эрүүл мэндийн шинжилгээ, эмчилгээнд хамруулах<br>- Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрт дэмжлэг үзүүлэх | - Аюулгүй байдлыг нь хангах, байрлуулах (Дундаж хугацаа 3 сар)<br>- Байрлах хугацаанд нь үйлчлүүлэгчийг нөхөн сэргээх үйлчилгээ, хөтөлбөрт хамруулах |
| **МЭРГЭЖИЛ ОЛГОХ СУРГАЛТ** | **ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БОЛОН ТҮҮНИЙ ГЭР БҮЛИЙН ОРЛОГЫГ ДЭМЖИХ** |
| - Мэргэжлээ сонгоход нь туслах<br>- Мэргэжил олгох сургалтад хамруулах, мэргэжлийн үнэмлэхтэй болгох<br>- Ажлын байртай болоход нь туслах зорилгоор бусад байгууллагатай холбож өгөх<br>- Амьдрах ухааны сургалтад хамруулах | - Жижиг бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэхэд нь туслах<br>- Энэ чиглэлээр сургалтад хамруулах, чадавхжуулах<br>- Боломжтой тохиолдолд өрхийн бичил бизнес эрхлэхэд туслах, дэмжих |

| ЭХ ОРОНД НЬ ЭРГҮҮЛЭН АВЧРАХ |
|---|
| - Хүлээн авагч улсад байгаа хохирогчийг сайн дураараа эх орондоо буцахад нь туслах<br>- Биеийн байцаалт, аяллын бичиг баримтыг бүрдүүлэхэд нь туслах<br>- Аюулгүйгээр эх оронд нь буцаахад туслах |

# ТАНЫ ЗАЙЛШГҮЙ МЭДЭЖ БАЙХ ЁСТОЙ АНХААРАХ ЗҮЙЛ:

## Хувийн бичиг баримтаа өөртөө хадгалаарай.



- Бичиг баримт, паспорт таны өмч учир хэн нэгэнд ямар нэгэн шалтгаанаар өгч болохгүй.
- Хэрвээ та шаардлагатай бол бичиг баримтаа хувилж, өөртөө хадгалаарай.

## Хийх ажлынхаа талаар бусадтай зөвлөлдөөрэй.



- Хаана, ямар ажил хийх, хэдэн төгрөгийн цалин авах талаар лавлаж мэдээрэй.
- Хэрвээ та ажлын саналыг хүлээн зөвшөөрч хийхээр шийдсэн ч эргэлзэж байгаа бол гэр бүлийнхэн болон бусад мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөөрэй.
- Боломж амласан ажлын саналууд нь эрсдэл дагуулдаг учир болгоомжлоорой.

## Эрсдэлтэй байдал тулгарвал хэрхэн тусламж хүсэх талаар мэдлэгтэй байгаарай.



- Яаралтай туслалцаа үзүүлэх байгууллагуудын утас, хаягийг мэдэж аваарай.
- Мөн гэр бүлийнхэнтэй байнга холбоотой байж тэдэнд өөрийнхөө талаар мэдээллийг үнэн зөв өгөөрэй.
- Байгаа газрынхаа хаяг, утсыг мэдэж аваарай.

## ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ, БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ТАЛААРХ АСУУЛТ, ХАРИУЛТ:

*Өөрсдийгөө шалгаад үзээрэй.*

- Хүн худалдаалах гэмт хэрэг зөвхөн гадаадад л үйлдэгддэг.
  Тийм/Үгүй
- Зөвхөн охид, эмэгтэйчүүд л энэ гэмт хэрэгт өртдөг.
  Тийм/Үгүй
- Бэлгийн мөлжлөгийн хохирогчид нь өөрсдийнхөө хийх ажлын талаар хангалттай мэдээлэлтэй байдаг.
  Тийм/Үгүй
- Хохирогчид гэмт хэрэгтэнд тавьсан өрөө төлөх ёстой.
  Тийм/Үгүй
- Гэмт хэрэгтэн нь хохирогчийг болон түүний гэр бүлийнхнийг заналхийлж, дарамталсан байдаг.
  Тийм/Үгүй
- Гэмт хэрэгтэн нь таны таньдаг ойр дотны хамаатан, найз нөхөд эсвэл танихгүй хүн аль нь ч байж болно.
  Тийм/Үгүй
- Хүн худалдаах гэмт хэргийн хохирогчийг заавал улсын хил давуулан худалдаалсан байх шаардлагагүй.
  Тийм/Үгүй

Хариу: Ү/Ү/Ү/Ү/Т/Т/Т

Та дараах байгууллагуудаас тусламж, үйлчилгээ авах боломжтой.

| Үйл ажиллагааны чиглэл | Байгууллагын нэр | Утас |
|---|---|---|
| Гэмт хэргийн талаар мэдээлэл өгөх | Цагдаагийн газар | 112<br>(Төлбөргүй холбогдох боломжтой.) |
| Хүүхдүүд 24 цагийн турш үнэ төлбөргүй холбогдож мэдээлэл зөвлөгөө болон хамгааллын үйлчилгээ авах боломжтой. | Хүүхдийн тусламжийн утас | 108<br>(Төлбөргүй холбогдох боломжтой.) |
| Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгт өртсөн болон бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх | Хүйсийн тэгш эрхийн төв ТББ | 1800-1903<br>(Ажлын цагаар, ердийн утасны тарифаар) |

| Монгол Улсын Элчин Сайдын Яамд | | |
|---|---|---|
| 1 | **АНКАРА**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа ЭСЯ | Mogolistan Buyukelciligi, A.Fethi Okyar Sokak No.4, Oran Diplomatik Sitesi, Cankaya, 06450 Ankara<br>Утас: 90 (312) 4921027, 90 (312) 4921028<br>Факс: 90 (312) 4921064<br>Цахим шуудан: ankara@mfa.gov.mn<br>Цахим хуудас: mongolianembassy.com.tr<br>Facebook: https://www.facebook.com/embmong/<br>Шуурхай утас: +90 3124921028, +905374077814 |
| 2 | **БАНГКОК**<br>Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in the Kingdom of Thailand, 100/3 Soi Ekkamai 22, Sukhumvit 63 Road, Klongton Nua, Wattana, Bangkok 10110<br>Утас: 66 (2) 381 1400, 66 (02) 392 1011<br>Факс: 66 (2) 392 4199<br>Цахим шуудан: bangkok@mfa.gov.mn<br>Facebook: https://www.facebook.com/mongembbkk/<br>Шуурхай утас: +66 818020930, +66 818022942, +66 828500027 |
| 3 | **БЕРЛИН**<br>Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа ЭСЯ | Botschaft der Mongolei Hausvogteiplatz, 14, 10117 Berlin<br>Утас: 49 (30) 47480611, Факс: 49 (30) 47480616<br>Цахим шуудан: berlin@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.berlin.embassy.mn<br>Facebook: https://www.facebook.com/BotschaftderMongolei/<br>Шуурхай утас: +49 17629990069 |
| 4 | **БЭЭЖИН**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа ЭСЯ | No 2, Xiu Shui Bei Jie, Jian Guo Men Wai, Beijing 100600<br>Утас: 86 (10) 6532 6512<br>86 (10) 6532 6513, 86 (10) 6532 1203<br>Факс: 86-10-6532-6216<br>Цахим шуудан: beijing@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.beijing.embassy.mn<br>Шуурхай утас: +86 15210304468, +86 13693382519, +86 18515969636 |
| 5 | **ВАРШАВ**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа ЭСЯ | Ambasada Mongolii, ul.Rejtana 15 m.16, 02516 Warszawa, Polska<br>Утас: 48 (22) 849 9391<br>Факс: 48 (22) 848 2063<br>Цахим шуудан: warsaw@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.ambasadamongolii.pl<br>Facebook: https://www.facebook.com/ESYWAW/<br>Шуурхай утас: +48 538286500 |

| | | |
|---|---|---|
| 6 | **ВАШИНГТОН**<br>Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia, 2833 M Street, NW Washington DC 20007<br>Утас: 1 (202) 333 7117, Факс: 1 (202) 298 9227<br>Цахим шуудан: washington@mfa.gov.mn<br>monconsul@mongolianembassy.us<br>Цахим хуудас: www.mongolianembassy.us<br>Facebook: https://www.facebook.com/MongoliaDC/<br>Шуурхай утас: +1 2028189020,+1 2022886002 |
| 7 | **ВЕНА**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа ЭСЯ | Botschaft der Mongolei, Fasangartengasse 45, 1130 Vienna, Austria<br>Утас: 43 (1) 5352807-0, Факс: 43 (1) 5352807-20<br>Цахим шуудан: vienna@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.vienna.embassy.mn<br>Facebook: https://www.facebook.com/MongolianEmbAustria/<br>Шуурхай утас: +43 6601893985 |
| 8 | **ДЕЛИ**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in the Republic of India, 34, Archbishop Macarios Marg, New Delhi 110003<br>Утас: 91 (11) 2461 7989, Факс: 91 (11) 2463 3240<br>Цахим шуудан: delhi@mfa.gov.mn |
| 9 | **ЛОНДОН**<br>Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in the United Kingdom, 7-8 Kensington Court, London, W8 5DL<br>Утас: 44 (207) 937 0150, 7252<br>Факс: 44 (207) 937 1117<br>Цахим шуудан: london@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.embassyofmongolia.co.uk<br>Facebook: https://www.facebook.com/Embassy-of-Mongolia-in-the-UK-1400255040231433/<br>Шуурхай утас: +44 7874916606 |
| 10 | **МОСКВА**<br>Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа ЭСЯ | Посольство Монголии в РФ, Борисоглебский пер.11, Москва, РФ 115127<br>Утас: 7-495-690-67-92<br>7-495-691-46-36 (Офис менежер)<br>7 (495) 695 43 70 (Элчин зөвлөх), 7 (495) 690 02 45 (Ёслол)<br>Факс: 7 (495) 691 46 36, Факс: 7 (499) 241 15 57, 7 (499) 252 78 67<br>Цахим шуудан: moscow@mfa.gov.mn<br>Consulate: mongolconsul@gmail.com<br>Facebook: https://www.facebook.com/embasmongru/<br>Шуурхай утас: +7 4992411548, +7 4956906792, +7 9162133247 |
| 11 | **ПАРИС**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа ЭСЯ | Ambassade de Mongolie, 5, Avenue Robert Schuman, 92100 Boulogne-Billancourt<br>Утас: 33 (1) 46052812, 33 (1) 4605 23 18 (Консул)<br>Факс: 33 (1) 46053016<br>Цахим шуудан: paris@mfa.gov.mn<br>Facebook: https://www.facebook.com/ambassademongolie/<br>Шуурхай утас: +33 626082898 |
| 12 | **ПРАГА**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа ЭСЯ | Velvyslanectvi Mongolska, Na Marne 5, Praha 6, 160 00 Ceska Republika<br>Утас: + 420 214 311 198, , Факс:420 (2) 24314827<br>Цахим шуудан: prague@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.prague.embassy.mn<br>Facebook: https://www.facebook.com/Embassy-of-Mongolia-to-the-Czech-Republic-420214891411555/<br>Шуурхай утас: +420 739 015 383, +420 775 874 222 |

| | | |
|---|---|---|
| 13 | **СӨҮЛ**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in the Republic of Korea, 95, Dokseo-dang-ro, Yongsan-gu, Seoul 140-885<br>Утас: 82 (2) 798 3464, 82 (2) 798 1950<br>Факс: 82 (2) 794 7605 (ЭСЯ), 82 (2) 798 3465 (Консулын газар)<br>Цахим шуудан: seoul@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.mongolembassy.com<br>Facebook: https://www.facebook.com/embassyofmongolia/<br>Шуурхай утас: +82 01082053464, +82 01027233464 |
| 14 | **СИНГАПУР**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in the Republic of Singapore, 600 North Bridge Road, #24-08 Parkview Square, Singapore188778<br>Утас: 65 63480745<br>Факс: 65 63481753<br>Цахим шуудан: singapore@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.mongolianembassy.sg<br>Facebook: https://www.facebook.com/EmbassyOfMongoliaInSingapore/<br>Шуурхай утас: +65 83534563 |
| 15 | **ТОКИО**<br>Монгол Улсаас Япон Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in Japan, 21-4 Kamiyama-Cho, Shibuya- Ku, Tokyo 150-0047<br>Утас: 81 (3) 3469-2088<br>81 (3) 3469 2195, 81 (3) 3469 2179 (Консулын газар)<br>81 (3) 3469 2162 (Ёслол), 9868-2299 (гар утас)<br>Факс: 81 (3) 3469 2216<br>Цахим шуудан: tokyo@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.tokyo.embassy.mn<br>Facebook: https://www.facebook.com/MongolEmb<br>Шуурхай утас: +81 9033191397 |
| 16 | **ХАНОЙ**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia to Socialist Republic of Vietnam<br>Villa No 6/44 Van Bao Street, Van Phuc Diplomatic Quarter, Ba Dinh, Hanoi, Vietnam<br>Утас: 84 (24) 384 53009<br>Факс: 84 (24) 384 54954<br>Цахим шуудан: hanoi@mfa.gov.mn<br>Facebook: https://www.facebook.com/MonEmbHanoi/<br>Шуурхай утас: +84 936050458, +84 901757164, +84 02438453009 |
| 17 | **СТОКГОЛЬМ**<br>Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in the Kingdom of Sweden, Svardvagen 25B, 182 33 Danderyd Stockholm<br>Утас: 46 (08) 7531135, 46 (08) 7531136<br>Факс: 46 (08) 7531138<br>Цахим шуудан: stockholm@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.stockholm.embassy.mn<br>Facebook: https://www.facebook.com/embassyofmongolia.sweden/<br>Шуурхай утас: +46 0733995557 |
| 18 | **КУВЕЙТ**<br>Монгол Улсаас Кувейт Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia to the State of Kuwait, Kuwait, Salwa area, Moutaz Street, villa 35<br>Утас: +965 25640208 / 25646020 / 25642262<br>Факс: +965 25648030<br>Цахим шуудан: kuwait@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.kuwait.embassy.mn<br>Facebook: https://www.facebook.com/Embassy-of-Mongolia-to-the-State-of-Kuwait-1433500206875841/<br>Шуурхай утас: +965 99064541 |

| Ерөнхий консулын газар, Консулын газар | | |
|---|---|---|
| 19 | **ХӨХ ХОТ**<br>Бүгд Найрамдах Хятад Ард Улс Хөх Хот дахь Ерөнхий Консулын газар | Zhongguo Huhe Haote, Xinchenqu Wulanxiaoqu 5 hao Lou Menguguo Zhonglinshiguan PRC<br>Утас: 86 (471) 4902531, 86 (471) 4902262<br>Факс: 86 (471) 4902531, 86 (471) 4303250<br>Цахим шуудан: huhhot@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.huhhot.consul.mn<br>Шуурхай утас: +86 15754936989, +86 04714902262 |
| 20 | **ХОНКОНГ**<br>БНХАУ-ЫН ЗЗОБ ХОНКОНГ Хонконг дахь Ерөнхий Консулын газар | Consulate General of Mongolia in Hong Kong and Macao Special Administrative Regions of the People`s Republic of China<br>Unit 1206, Tower 1, Lippo Centre<br>89 Queensway, Admiralty, Hong Kong<br>Утас: 852 25222400, Факс: 852 25222405<br>Цахим шуудан: hongkong@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.hongkong.consul.mn<br>Facebook: https://www.facebook.com/ConsulateGeneralofMongoliaHK/<br>Шуурхай утас: +852 25222400, +852 93057096 |
| 21 | **ИСТАНБУЛ**<br>Бүгд Найрамдах Турк Улс Истанбул дахь Ерөнхий Консулын газар | Consulate General of Mongolia in Istanbul, Levent Mahallesi, Levent Caddesi, Gьvercin sokak, No: 37, BEŞİKTAŞ/ İSTANBUL/ TURKEY<br>Утас: 90 (212) 662 6162 141<br>Цахим шуудан: istanbul@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.istanbul.consul.mn<br>Facebook: https://www.facebook.com/ekgistanbul<br>Шуурхай утас: +90 5513970531, +90 5078253510, +90 5435939079 |
| 22 | **ЭРХҮҮ**<br>Оросын Холбооны Улс Эрхүү дэх Ерөнхий Консулын газар | Генеральное Консульство Монголии, Ул.Лапина 11, Иркутск, РФ 664003<br>Утас: 7 (3952) 342447 (Консул)<br>Факс: 7 (3952) 342143<br>Цахим шуудан: irkutsk@mfa.gov.mn<br>Facebook: https://www.facebook.com/generalconsulateirkutsk/<br>Шуурхай утас: +7 3952 342295, +7 914 895 0528 |
| 23 | **ШАНХАЙ**<br>Бүгд Найрамдах Хятад Ард Улс Шанхай хот дахь Ерөнхий консулын газар | Consulate of Mongolia in Shanghai, 1428. Podung South road. Shanghai<br>Утас: 21+ 68473255, Факс: 21+ 68473206<br>Цахим шуудан: shanghai@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.shanghai.consul.mn<br>Шуурхай утас: +86 13162982707, +86 13162982596, +86 2168473255 |
| 24 | **САН ФРАНЦИСКО**<br>Америкийн Нэгдсэн Улс Сан Франциско дахь Ерөнхий Консулын газар | Consulate General of Mongolia in San Francisco, Suite 200, Merchants Exchange Building, 465 California St.San Francisco, CA 94104, USA<br>Утас: 1 (415) 622 4000<br>Факс: 1 (415) 622 3000<br>Цахим шуудан: sanfrancisco@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.sanfrancisco.consul.mn<br>Facebook: https://www.facebook.com/mongolconsulsf/<br>Шуурхай утас: +1 415 215 2487 |

| | | |
|---|---|---|
| 25 | **ОСАКА**<br>Япон улс<br>Осака хот дахь<br>Ерөнхий Консулын<br>Газар | Consulate General of Mongolia in Osaka, 3f Estate Bakurochiyou BLDG 1-4-10 Bakuromachi,Chuo-ku, Osaka City Japan 541-0059<br>Утас : 81 (6) 4963-2572, Факс: 81 (6) 4963-2574<br>Цахим шуудан: osaka@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.osaka.consul.mn<br>Facebook: https://www.facebook.com/ConsulateGeneralOfMongoli-aInOsaka/<br>Шуурхай утас: +81 649632572 |
| 26 | **УЛААН-ҮД**<br>Оросын Холбооны<br>Улс<br>Улаан Үд дэх<br>Ерөнхий Консулын<br>газар | Генеральное Консульство Монголии, Ул.Профсоюзная 6, Улан-Удэ, РФ 670000<br>Утас, Факс: 7 (3012) 215275 (Консул)<br>Утас, Факс: 7 (3012) 210507<br>Утас, Факс: 7 (3012) 220139 (Ерөнхий консулын нарийн бичиг)<br>Утас: 7 (3012) 220499<br>Цахим шуудан: ulan-ude@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.ulan-ude.consul.mn<br>Facebook: www.facebook.com/Улаан-Үд-дэх-Ерөнхий-Консулын-Газар-102133027831502<br>Шуурхай утас: +7 (3012)220499, +7 9516224225, +7 9025337213 |
| 27 | **ПУСАН**<br>Бүгд Найрамдах<br>Солонгос Улс<br>Пусан дахь Консулын<br>газар | Consulate of Mongolia in Busan 11,  Haeun-daero 774beon-gil, Haeun-dae-gu, Busan, 48104, Republic of Korea<br>Утас: 051 (465) 9996, Факс: 051 (465) 9997<br>Цахим шуудан: busan@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.busan.consul.mn<br>Facebook: www.facebook.com/Consulate-of-Mongolia-in-Busan-Пусан-хотод-суугаа-Консулын-газар-757598521038617/<br>Шуурхай утас: +82 010 4966 7103 |
| 28 | **ЭРЭЭН**<br>Бүгд Найрамдах<br>Хятад Ард Улс<br>Эрээн дэх Консулын<br>газарг | Consulate of Mongolia in Erlian, No.1206, Youyi Beilu Erlianhaote, Inner Mongolia, PRC 011100<br>Утас: 976 92269000<br>Факс: 86 (479) 7589201<br>Цахим шуудан: ereen@mfa.gov.mn<br>Цахим хуудас: www.ereen.consul.mn<br>Шуурхай утас: +86 15647964334 |

**Биеэ үнэлэлт,**
**бэлгийн мөлжлөгийг**
**таслан зогсооё!**




**1800-1903**